

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2018 ОНЫ
07, 08 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2018.09.07

Нэг. Зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй уялдуулж батлуулсан бүтцийн нэгжүүдийн 07, 08 дугаар сарын ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, мэдээллээр хангах, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хоёр. Үнэлгээ

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлыг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт буюу хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж, хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ нэгжүүдийн ажлын төлөвлөгөөний биелэлт, сарын ажлын тайланг үндсэн материал болгон ашигласан.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажлын тоо		Хэрэгжилтийн байдал /хувиар/					Нэгжийн дүн
	7 сар	8 сар	Бүрэн хэрэгжсэн 100 хувь (90-100 хүртэл хувь)	Хэрэгжих шатанд 70 хувь (50-89 хүртэл хувь)	Хэрэгжилт хангалтгүй 30 хувь (10-49 хүртэл хувь)	Хэрэгжээгүй 0 хувь (0-9 хүртэл хувь)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
ХЗХБХ	4	9	10	2	1	-	-	86,92
ТМССХ	14	12	22	3	-	-	1	94,80
ЗСХ	9	21	25	3	1	1	-	91,33
Дүн	27	42	57	8	2	1	1	91,76

Гурав. Санал, зөвлөмж

ХЗХБХ-т:

1. 2018 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан тусгай захиалгат арга хэмжээ болох “... **салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах**” ажлын “зорилтот түвшин” нь “нэгдсэн тооллого, бүртгэл хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж танилцуулсан байна” гэсэн учир хэрэгжиж дуусахад хүрэхээр хүлээгдэж буй үр дүнд бүрэн хүргэхэд чиглэсэн төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2. Суурь бүтэц дэх галт тэрэгний хөдөлгөөний өвлийн нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хийсэн шинжилгээний хүрээнд “Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам”-ын 6.6-д заасны дагуу нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тайланд дурдсан зөвлөмжийн биелэлтийг суурь бүтэц эзэмшигчээс албан ёсоор авах;

3. ЗТХ-ийн сайдын 2018.07.23-ны өдрийн “Төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 27 дугаар тушаалын 4 дэх заалтын хэрэгжилтийг хангуулах талаар “МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-д албан бичиг хүргүүлж, сар бүрийн 10-ны дотор яамны ХШҮДАГ-т тайлагнах ажлыг тогтмолжуулах арга хэмжээ авч ажиллах;

ХЗХБХ, ТМССХ-т:

4. <<“МТЗ” ТӨХК, “БТЕГ” ХХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох>> арга хэмжээг үр дүнд хүргэх чиглэлээр мэргэжлийн нэгжүүд нягт холбоотой, хамтарч ажиллах;

5. “Төмөр замын хөгжил, салбарын ажилтнуудын нийгмийн асуудал” сэдэвт зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3-т тусгагдсан “Төмөр замын салбарын цахим мэдээлэл солилцоог хөгжүүлж нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх;

ЗСХ-т:

6. Төвийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны эмх цэгцийг хангаж ажиллах, үйл ажиллагаатай холбоотой Захирлын тушаал болон ирсэн, явсан албан бичгийн цахим хадгалалтыг нөхөн хөтлөх, и оффист байршуулах;

7. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн тайлан, мэдээг тогтмол гаргаж, мэдээллийн самбарт байршуулж мэдээлэх;

8. VIII сарын төлөвлөгөөний биелэлтээр удаашралтай дүгнэгдсэн 3 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дуусгах;

Нийтлэг:

9. Үр дүнгийн гэрээний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгавар, төвийн үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан санал зөвлөмжийг ажлын төлөвлөгөөндөө тусгаж, эсхүл туслах чанараар тусгайлсан төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

10. Архив, албан хэрэг хөтлөлтийн журмыг хэрэгжүүлж ажилтнууд боловсруулсан захирлын тушаалын төслийг эрх зүйн асуудал хариуцсан ажилтнаар, төсөв, санхүүтэй холбоотой тушаалын төслийг нягтлан бодогчид заавал танилцуулж гарын үсэг авч байх;

11. ЗТХЯ, төмөр замын болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичгийнхээ араас хөөцөлдөх, асууж сураглах ажиллагааг боловсруулсан ажилтан гүйцэтгэх, үүнд нэгжийн дарга нар нь хяналт тавих.

ХЯНАСАН:

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:

ХЗХБХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА